



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 4115

Улаанбаатар хот

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 8.2.1.14 дэх заалт, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.6, 28.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаягдал тос болон бүтээгдэхүүн хадгалах, нэрэх үйл ажиллагаа явуулдаг “Алтан оршихуй” ХХК-д үйлдвэрлэл, унд ахуйн зориулалтаар ус ашиглах зөвшөөрлийг олгосугай.

2.Ус ашиглагч байгууллагад ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулан, төлбөр хураамжийн төлөлт, гэрээний биелэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, ус авах цэгт тоолуур байрлуулан тавигдах шаардлагуудыг биелүүлж, жил бүр тайлагнаж ажиллахыг “Алтан оршихуй” ХХК (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД